



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Президент спорт комплекс” (President Sport Complex) цогцолбор барих төслийн ажилд дэмжлэг үзүүлж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- Дарга: -Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ
- Гишүүд: -Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх О.Буяннэмэх (зөвшилцсөнөөр);
- Монгол Улсын Ерөнхий сайдын биеийн тамир, спортын бодлогын зөвлөх Я.Төмөрбаатар;
- Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Г.Түвдэндорж;
- Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг;
- Гадаад харилцааны дэд сайд Г.Амартүвшин;
- Барилга, хот байгуулалтын дэд сайд Э.Золбоо;
- Эрчим хүчний дэд сайд М.Баярмагнай;
- Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн;
- Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны Ажлын албаны дарга Э.Тэмүүжин;
- Монголын бодибилдинг, фитнесийн хөгжлийн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Ш.Амарсайхан (тохиролцсоноор);
- Монгол Улсын тэргүүлэх инженер Г.Баттөр (тохиролцсоноор).

Нарийн бичгийн
дарга:

-Барилга, хот байгуулалтын яамны Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Гантулга;

-Биеийн тамир, спортын улсын хорооны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга О.Баттулга.

2.“Президент спорт комплекс” (Presedent Sport Complex) цогцолбор барих төслийн ажлын хэрэгжилтийг эрчимжүүлж, явц байдлыг тухай бүр нь танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Бат-Эрдэнэ)-т даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ